

# НАРГИЛ МОДНЫ САМАР БА АРАВНЫ НЭГ



Авэхэй М., 11  
настай, Тахити,  
Францын  
Полинез

Сайн уу? Намайг Авэхэй гэдэг. Би Тахитид амьдардаг! Би арал дээрээ гадаа байх дуртай. Би ууланд алхаж, голд эсвэл далайд сэлдэг. Би бас гэр бүлийнхэнтэйгээ хамтдаа юм хийх дуртай. Би хоол хийх, хөзөр тоглох, ууланд алхах, ах, үеэл нарынхаа хамт бөмбөг тоглох, модонд авирах дуртай.

Би зуны амралтаараа ахтайгаа хамт наргил модны төгөлд ажилладаг. Бид наргил модыг цуглуулж, овоолж тавьдаг. Мөн төглийг цэвэрхэн байлгахын тулд унасан навчсыг түүдэг.

Биднийг төгөлд ажиллахад элэнц өвөө маань бидэнд цалин өгдөг байв. Би авсан цалингаасаа үргэлж аравны нэгээ төлдөг. Аравны нэгээ хэрхэн төлөхийг би гэр бүл, Хүүхдийн хэсгийн багш нараасаа сурч мэдсэн.

Дуулгавартай байх үед маань намайг болон гэр бүлийг маань адисалдаг гэдгийг мэддэг учраас би аравны нэгээ төлдөг. Би гэр бүл, гэр орон, үзэсгэлэнтэй дэлхий ертөнцөөр адислагдсан.

Бурхан амьд бөгөөд намайг хайрладаг гэдгийг би мэднэ. Тэнгэрлэг Эцэг надад гэр бүл өгсөнд би талархдаг. ●



## АРАВНЫ НЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Сүмийн гишүүд орлогынхоо аравны нэгийг Бурханы Сүмтэй хуваалцдаг. Бидний аравны нэгийн мөнгө ариун сүм, мөн сүмийг барихад болон гачигдагсдад туслахад дэм болдог. Аравны нэг бол адислалаа бусадтай хуваалцах нэг арга зам юм. Бурхан бидэнд энэ зарлигийг аль эрт, Хуучин Гэрээний үед өгсөн (Эхлэл 14:18–20-ыг үзнэ үү). Аравны нэгээ төлөх нь Тэнгэрлэг Эцэгт хайраа харуулах нэг арга зам юм.

